



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Төлөвлөгөө боловсруулах  
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/173 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагуудын гамшгийн үед ажиллах төлөвлөлт, чадавхыг сайжруулах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй газар хөдлөлт, хүн, мал амьтны гоц халдварт өвчин, ой хээр, объектын гал түймэр, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, цацраг химийн ослын төрөл тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан ажлын хэсгийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг дүүргийн нутгийн захиргааны байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, ажлын хэсгүүдийн боловсруулсан төлөвлөгөөг нэгтгэн 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн дотор дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 03 дугаар сарын 04 -ны өдрийн 43 дугаар  
захирамжийн хавсралт



НЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕД АЖИЛЛАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Дарга:

- Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд:

- Засаг даргын Тамгын газрын дарга
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Боловсролын хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Газар зохион байгуулалтын албаны дарга
- “Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал
- “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал
- “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга
- “Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн мастер
- УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга,
- Нэгдүгээр хорооны Засаг дарга
- Хоёрдугаар хорооны Засаг дарга
- Улаан загалмайн хорооны дарга

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга

ХОЁР.ХҮН, МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ҮЕД  
АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Дарга:

- Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал
- “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал
- Нэгдүгээр хорооны Засаг дарга
- Хоёрдугаар хорооны Засаг дарга

Нарийн бичиг:

- Мал эмнэлгийн тасгийн дарга

ГУРАВ.ОБЪЕКТЫН БОЛОН ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН  
ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Дарга:

- Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга

Гишүүд:

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Газар зохион байгуулалтын албаны дарга
- "Илч-орд" ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч

ДӨРӨВ.УС, ЦАГ УУРЫН АЮУЛТАЙ БОЛОН ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ,  
ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Дарга:

- Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Боловсролын хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- "Илч-орд" ОНӨААТҮГ-ын захирал
- "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын захирал
- "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга
- "Налайх" эрчим хүчний Багахангай хэсгийн мастер

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

ТАВ.ЦАЦРАГ, ХИМИ БОЛОН ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИСЫН  
ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Дарга:

- Цэргийн штабын дарга

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Боловсролын хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Онцгой байдлын хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- "Илч-орд" ОНӨААТҮГ-ын захирал
- "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын захирал
- "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч